



**OTGONTENGER
UNIVERSITY**
SINCE 1991

ЕВРОП СУДЛАЛ Х

"ХЭЛ ШИНЖЛЭЛ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, ОРОН СУДЛАЛ" ОЛОН УЛСЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Хэзээ: 2026 оны 4-р сарын 10-ны өдөр 10.00 цагт

Хаана: ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн төв номын сангийн 6 давхарт 604 тоот хурлын танхим

Зохион байгуулагч:

ШУТИС-ийн Гадаад хэлний сургууль, Хэрэглээний хэл шинжлэлийн тэнхим
МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Европ судлалын тэнхим
МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль
Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль
Отгонтэнгэр Их Сургууль

Хурлын зорилго:

Монгол улсад баруун, төв, зүүн Европын улс орны хэл, уран зохиол, түүх, соёл, боловсрол, нийгэм эдийн засаг, олон улсын харилцаа, улс төр судлалыг хөгжүүлэх, их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын багш, судлаачдын мэдлэгийг түгээх, чадавхыг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох, цаашид хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг хэлэлцэх, Европ судлалыг олон улсын харилцаа, орон судлал, хэл шинжлэл ба орчуулга зүй, гадаад хэлний боловсролын орчин үеийн сургалт, судалгааны чиг хандлагад ойртуулах зорилготой.

Хурлын хамрах хүрээ:

Гадаад, дотоодын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод оролцох боломжтой.

Салбар хуралдаан:

- Олон улсын харилцаа, орон судлал
- Хэл шинжлэл, орчуулга зүй
- Гадаад хэлний боловсрол

Хурлын албан ёсны хэл: Монгол, Англи

Сэдвийн хамрах хүрээ:

- **Олон улсын харилцаа, орон судлал:** Монгол улс болон Европын орнуудын хамтын ажиллагаа, олон улсын харилцаа, бүс нутаг судлал, Европын орнуудын түүх, нийгэм, улс төр, соёл судлал, соёл хоорондын харилцаа;
- **Хэл шинжлэл, орчуулга зүй:** Орчин цагийн хэл шинжлэлийн онол, арга зүй, салбарын болон салбар дундын судалгаа, орчуулгын онол, зарчим, арга, төрөл, орчуулгын шүүмж, утга зохиол судлал;
- **Гадаад хэлний боловсрол:** Гадаад хэл эзэмших онол, арга зүйн асуудал, салбарын судалгааны онол, арга зүйн хувьд шинэлэг санаа дэвшүүлсэн байх

Илтгэлд тавигдах шаардлага:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг санаа агуулсан, өмнө нь хэлэлцүүлээгүй байх
- Илтгэлийн нэр, хураангуйг монгол, англи хэлээр бичсэн байх
- Илтгэлийн бүтэц: 3-5 түлхүүр үг, 150-иас доошгүй үгэнд багтаан монгол, англи хэлээр бичсэн хураангуй, оршил, үндсэн агуулга, дүгнэлт, ном зүй, зураг хүснэгтийн жагсаалт хавсаргах, зургийг JPG, TIFF, хүснэгтийг Microsoft Excel программаар хавсаргах
- Илтгэлийг Microsoft Word программ ашиглан бичих
- Үсгийн фонт: Times New Roman, үсгийн хэмжээ: 11, мөр хоорондын зай: single, догол мөр: 0.2 тэмдэгт
- Илтгэлийн хэмжээ: А4 цаасны хэмжээтэй 5-10 хуудас
- Илтгэлийн эхэнд илтгэлийн нэр /сэдэв/, зохиогчийн овог, нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй ажил, харилцах утасны дугаар, цахим хаягийг бичих
- Илтгэлийн PPT бэлдсэн байх

Илтгэлийг бүрэн эхээр илгээх хугацаа: 2026 оны 2-р сарын 28

Илтгэлийг хянан магадалж хариу илгээх хугацаа: 2026 оны 3-р сарын 1

Илтгэлд засвар хийж илгээх эцсийн хугацаа: 2026 оны 3-р сарын 10

Илтгэл илгээх и-мэйл хаяг: europeanstudies2026@gmail.com

